



## УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

### Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, 122.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” Засгийн газрын 2020 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 151 дүгээр тогтоол, “Улаанбаатар лифт” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 2 дугаар хэсгийн 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтын “Ур чадварын нэмэгдэл 10-25 хувь, төрд алба хаасан хугацааны нэмэгдэл 5 хүртэл хувь олгоно” гэснийг “Ур чадварын нэмэгдэл 10-25 хувь, төрд алба хаасан хугацааны нэмэгдэл 5-25 хүртэл хувь олгоно” гэж өөрчилсүгэй.

2. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтын “Ажилтны төрсөн болон хадам эцэг, эх, өвөө, эмээ, эхнэр, нөхөр, хүүхэд нас барсан тохиолдолд 100'000 хүртэл төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно” гэснийг “... хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно”, 4.2.10 дахь заалтын “Шинээр гэр бүл болж, гэрлэлтээ эрх бүхий байгууллагад бүртгүүлэхэд 100'000 хүртэл төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно” гэснийг “... хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно”, 4.2.11 дэх заалтын “Ажилчдын гэр бүлд нь шинэ хүүхэд мэндэлсэн эсхүл хүүхэд төрүүлсэн, 3 нас хүртэлх хүүхэд үрчлэн авсан бол 100'000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно” гэснийг “... хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Хөдөлмөрийн дотоод журамд заасан албан хаагчдад олгох ур чадвар, төрд алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход зарцуулагдах зардлыг жил бүрийн байгууллагын төсөвт суулгаж, санхүүжүүлж олгохыг Ахлах нягтлан бодогч (З.Ариунтуяа)-д даалгасугай.

4. Шинэчлэн тогтоосон ур чадвар, төрд алба хаасан хугацааны нэмэгдэл, нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөж, олгосугай.

ДАРГА



Д.ГАН-ЭРДЭНЭ